

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын 2020 оны ээлжит
сонгууль**

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ТҮВДЭНДАНСРАНГИЙН УУГАНБАЯРЫН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Хөвсгөл аймаг, Мөрөн хот

2020 он



Handwritten signatures and a red stamp are visible at the bottom of the page. The red stamp is located on the right side and contains some illegible text.

ОРШИЛ

Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр Түвдэндансрангийн Ууганбаяр сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050", Хөгжсөн Хөвсгөл 2030-д нийцүүлэн боловсруулсан баримт бичиг болно.

Аймаг, орон нутагт сүүлийн жилүүдэд үүссэн ардчиллын болон тогтолцооны гажуудлыг засч, үндэсний язгуур эрх ашиг, түүх соёл, уламжлал, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, хүний хөгжил, хууль ёс, шударга ёс, нийгмийн ардчиллыг дээдэлсэн хүмүүнлэг, аз жаргалтай нийгмийг цогцлоон байгуулах зорилгоор, Хөвсгөл аймгийн хөгжлийн урт хугацааны зорилтыг ханган биелүүлэх мөн Хөвсгөл аймгийн Хөгжсөн Хөвсгөл 2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд, нотолгоонд суурилсан судалгаанд үндэслэн энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулав. Хөвсгөл аймаг төлөвлөснийхээ дагуу хөгжиж, дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн алхъя гэвэл дотоодын жижиг зах зээлд хоорондоо хэт өрсөлдөж, хүч нөөцөө барах бус, дэлхийн зах зээлд өрсөлдөх зарчмыг баримтлах нь чухал тул тулгарч буй асуудлаа эрэмбэлсэн хөгжлийн стратеги боловсруулах шаардлагатай. Хөгжлийн стратеги нь нэн тэргүүнд Монгол хүний төлөө анхаарч, бусад салбаруудыг хөтлөх, хөгжлийн салхийг хагалах чиглэл гэж би үзэж байна. Үүнд:

Уриа: Зөв монгол хүн, эрүүл нийгмийг бүтээнэ.

1. ХҮНЭЭ ХӨГЖҮҮЛЭХ, ХҮНДЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ

Боловсролтой, эрүүл, зөв монгол хүн эх орноо авч явна.

- Иргэн бүр нь нийгмээ, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг, шударга ёс, зөв ёс ноёлсон шударга зөв нийгэм цогцлоон байгуулахын төлөөх шинэчлэлийг удирдан манлайлна.
- Улсын үндэс нь болсон иргэнээ дээдэлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, ахмадаа хүндэлдэг, хүүхэд балчираа хайрладаг, өндөр ёс суртахуунтай, журам жудагтай Монгол иргэнийг хөгжүүлэхийг эрхэмлэнэ.
- Хууль дээдэлдэг, хууль нь хүн бүрт тэгш үйлчилдэг, шударга нийгмийн төлөө тууштай тэмцэнэ.
- Бусдыг хүндэтгэдэг, үнэн, зөвийг эрхэмлэдэг, ёс зүйн хүмүүжлийг бага наснаас нь суулгах, аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлээс үл хамаарсан тэгш хамруулан сургалтыг ерөнхий боловсролд бүрэн нэвтрүүлэхийг дэмжинэ. Үе тэнгийн дээрэлхэлт, цахим гадуурхалтыг бууруулахыг зорино.

67171
РЮАССС

Эрүүл мэндийн салбарын удирдлага, санхүүжилтийг оновчтой болгож үр ашгийг сайжруулж, иргэдэд хүртээмжтэй болгоно.

- Эрүүл мэндийн даатгалаар оршин суугаа хаяг, өмчийн хэлбэр үл харгалзан үйлчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Эрүүл мэндийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог боловсронгуй болгох, дотоод гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтлана.
- Эрүүл мэндийн ажилтны үнэлэмжийг нэмэгдүүлнэ. Эмч, сувилагч нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх ажлыг дэмжинэ.
- Архи, тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, бусад төрлийн донтолт, хорт зуршлын хамааралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулна.
- Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, эмчилгээний үйлчилгээг хөгжүүлж, олон нийтэд хүртээмжтэй, боловсронгуй болгоно.

Ажлын байрыг нэмэгдүүлэх.

- Нийгмийн тэгш байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн орлогын ялгааг багасгах эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлж, нийгэмд дундаж орлоготой хүчирхэг давхаргыг тэлэх бодлого барина.
- Хөдөлмөрийн харилцаанд хүн төвтэй хандлагыг бэхжүүлж, Үйлдвэрчний эвлэлийн хөдөлмөрийн харилцааг дэмжинэ.
- Нийгмийн баялгийг зохистой, шударга хуваарилах, эдийн засгийн хөгжлийг тэтгэх орон нутгийн татвар, хураамжын оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.
- Нийгмийн халамжийн хүртээмж, оновчтой байдлыг сайжруулна.
- Хашаандаа аж ахуй эрхлэж, амьжаргаагаа дээшлүүлэх ажлыг дэмжинэ. Иргэд хашааныхаа ашиглагдахгүй байгаа хэсэг газрыг экологид ээлтэй, амьжиргааны чанартай ашиглаж, наад захын өдөр тутмынхаа хүнсний хэрэглээний шаардлага хангавал аймаг, орон нутгийн эдийн засаг, экологийн тэнцвэр, өрх гэрийн амьжиргааны түвшид ахиц гарч, гэр хороолол гэх эл хуль, тоос шороотой орчин нь хаус бүхий эдлэн, ногоон байгууламж, чинээлэг амьдралын эх булаг болж хувирна. Ийм боломж газартай хүн бүрт бий.

2. БАЙГАЛЬД ОЙР ЗӨВ ХӨГЖИЛ

Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж болдгийн үлгэр жишээг Хөвсгөлчүүд бид үзүүлж чадна.

- Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг манлайллыг дэмжиж, бүх салбаруудад байгаль орчинд ээлтэй соёлыг нэвтрүүлж, уламжлалт эко соёлыг бизнесийн боломж болгохыг дэмжинэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.
- Гэр хорооллыг хувийн сууц, нийтийн орон сууц хосолсон тохилог хороолол болгох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. Гэр хороололд мод, ургамал тарих, арчилахад иргэд, байгууллагуудыг дэмжинэ.

3. ЦЭВЭР, АВЛИГАГҮЙ ТӨР

Төрөө цэвэрлэж, хүчтэй болгож байж Монгол Улс сэргэн хөгжинө.

Төрийн албыг улс төрийн хүлээснээс чөлөөлж, улс төрийн зорилгоор наймаалцах, улс төрийн томилгоо, хууль бусаар төрийн албан хаагчийг халах байдлыг таслан зогсооно. Мэргэжлийн ур чадвар бүхий ёс зүйтэй төрийн албан хаагчийг төрийн албанд тогтвортой ажиллах боломжийг хангана.

- Төрийн албыг эрх мэдэлд хүрэх, тендер, концесс, ЖДҮ гэх мэт сан, улсын төсвөөс шимэгчлэн амьдрах үүр болгосон улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн далд-давхар эдийн засгийн гаж тогтолцоог өөрчлөхийг зорино.
- Авлигын сүлжээнд ороогүй, авлигатай тэмцэх улс төрийн чин хүсэл, ёс зүйтэй цэвэр улс төрчид болон тэдний хамтын ажиллагаагаар улс төрийн манлайллыг бий болгоно.
- Захиргааны байгууллагаас гарч байгаа шийдвэрт иргэн, аж ахуйн нэгж байгууллагын саналыг тусгаж, хуулиа хэрэгжүүлж ажиллахыг эрхэмлэнэ.
- Авлигын эсрэг нийтийн хөдөлгөөнийг идэвхижүүлнэ. Хүүхэд, залуу үеэдээ авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн бүх гишүүдийн оролцоо, дэмжлэгийг авна.
- Орон нутгийн өмч, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, шийдвэрлэлтэд иргэдийн хяналтыг сайжруулж, нэмэгдүүлнэ.
- Ёс суртахууны доройтол, архидалт, мансуурал, садар самуун зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд тууштай тэмцэж нийгмийг эрүүлж, хөгжүүлнэ.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ НЭР ДЭВШИГЧ /ГОРИЛОГЧ/
ТҮВДЭНДАНСРАНГИЙН УУГАНБАЯР
ХӨВСГӨЛ АЙМАГ, МӨРӨН ХОТ, 10.17.07 ТООТ
УТАС: 99931139

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ТҮВДЭНДАНСРАНГИЙН УУГАНБАЯРЫН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 ОН